



ДАРХАН-УУЛ АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 01 сарын 16 өдөр

Дугаар 03

Дархан

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Сангийн сайдын 2016 оны “Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дархан-Уул аймгийн 23 дугаар цэцэрлэгийн балансад бүртгэлтэй 16,554,034.0 /Арван зургаан сая таван зуун тавин дөрвөн мянга гучин дөрвөн/ төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг хавсралтын дагуу тус аймгийн 6 дугаар цэцэрлэгийн балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг шилжүүлэх ажлыг хуулийн хүрээнд зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Насанбат/-д даалгасугай.

ДАРГА



Г.ЭРДЭНЭБАТ

0010005